



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2019 оны 05 сарын 31 өдөр


Дугаар 8/258

Улаанбаатар хот

Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд
мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам”-ын 2.17 дах заалт, Хавдар судлалын үндэсний төв, Бүгд Найрамдах Солонгос Улсын Самсунг Эрүүл мэндийн төв хооронд 2018 оны 05 дугаар сарын 30-ны өдөр байгуулсан “Хамтын ажиллагааны тухай санамж бичиг”-ийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох 1 гадаадын эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг хавсралтаар баталсугай.
2. Зөвшөөрлийн гэрчилгээг баталгаажуулж олгох үйл ажиллагааг зохион байгуулахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Д.Ганцэцэг/-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Б.Цогтбаатар/-д даалгасугай.



САЙД

Д.САРАНГЭРЭЛ

081012

Эрүүл мэндийн сайдын
2019 оны 05 сарын 05-ны өдрийн
... дугаар тушаалын хавсралт

М/ЗС

МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ
ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ,
ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХУЧИНТЭЙ ХУГАЦАА

№	Овог нэр	Харьяалал	Монгол Улсад ажиллах байгууллага	Хамтран ажиллах гадаадын байгууллага	Гэрчилгээний сери/дугаар чиглэл	Төрөлжсөн мэргэшлийн чиглэл	Зөвшөөрлийн лийн төрөл	Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа
1.	Ким Жонг Ман Kim Jongman	Бугд Найрамдах Солонгос Улс	Хавдар судлалын Үндэсний төв	Бугд Найрамдах Солонгос Улсын Самсунг Эрүүл мэндийн төв	ГЭ0002292	Элэг шилжүүлэн суулгах мэс засал судлал	Эмчлэх	2019.06.05-2019.06.09 /5 хоног/